

Бит

Битландад олон зуун жил хэрэглэгдэж ирсэн Бит++ хэл нь зөвхөн ганц хувьсагчтай (X), зөвхөн хоёр үйлдэлтэй.

- `++` үйлдэл нь хувьсагчийн утгыг 1-ээр нэмэгдэнэ.
- `--` үйлдэл нь хувьсагчийн утгыг 1-ээр хорогдуулна.

Бит++ хэлний **илэрхийлэл** нь зөвхөн хувьсагч дээрх нэг үйлдэл байх ба хувьсагч үйлдэл хоёрын хооронд ямар ч зайгүйгээр бичигдэнэ.

Бит++ хэлний **програм** нь илэрхийллүүдийн дараалал байдлаар бичигдэнэ.

Танд Бит++ хэл дээрх програмын код өгөгдөнө (X -н анхны утга 0-тэй тэнцүү). Програм ажиллаад дуусахад гарах X -н утгыг олно уу.

Input

Эхний мөрөнд илэрхийллүүдийн тоог илэрхийлэх тоо n ($1 \leq n \leq 150$).

Дараагийн n мөрөнд мөр бүрд нэг илэрхийлэл байна. Илэрхийлэл зөвхөн X хувьсагч дээр хийгдэж байгаа `++` юм уу `--` үйлдлээс тогтох ба зөвхөн "-", "+", "X" тэмдэгтүүдийг агуулна. Хоосон үйлдэл гэж байхгүй ба хувьсагч үйлдэл хоёр ямар ч дарааллаар байрлаж болно.

Output

X -н эцсийн утгыг хэвлэнэ.

Example

Input 1:

```
1
++X
```

Output 1:

```
1
```

Input 2:

```
2
X++
--X
```

Output 2:

```
0
```